



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/24/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум
2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/196

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЭХ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.ГАНБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн захирал М.Ганбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, элэгдэл дууссан ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, өглөг, авлагын тооцоог барагдуулах, тооцоо нийлж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 1 зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ний захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Р.Пүрэвсүрэн, туслах аудитор Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа Уул аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сургуулийн бүхий л бодлого төлөвлөлтөөр хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаатай багш, ажилтан, бага боловсролд эх хэлний чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай сурагч төлөвшүүлж, суурь боловсролд амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадварт бие даан бүтээлчээр суралцах чадамжтай сурагч төлөвшүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон байна.

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна..

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ний “Acolous, payroll” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 548,261,3 мянган төгрөгөөс тооцон 5,482,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,482,6 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,062,7 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	150,0	300,3	150,3
Бараа материал	74,362.7	74,979.6	616.9
Үндсэн хөрөнгө	529,590.5	538,886.0	9,295.5
Нийт хөрөнгө	604,103.2	614,165.9	10,062.7
Өр төлбөр	170.0	170.0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	603,933.3	613,996.0	10,062.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	604,103.2	614,165.9	10,062.7

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь төлбөртэй сурах бичгийг бусад хангамжийн материал дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө дансанд 25,674.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 34,483.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 1 хөтөлбөрт зориулан 520,535.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 519,677.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 455,000.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 65,535.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 519,677.4 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 61,203.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 61,203.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн 61,203.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цаашид харилцагч байгууллагуудтай тухай бүрд тооцоо нийлж актаар баталгаажуулах, шатахууны тооцоо бодолтод анхаарал хандуулах чухал гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургууль нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 151 мэдээлэл байршуулахаас 126 мэдээллийг хугацаанд нь, 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,074.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлснээс 7,074.8 мянган төгрөгийн 4 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа 80% тай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДББОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хөрөнгийн ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Хувь хүн, аж ахуйн нэгж нийт 33 байгууллага тооцоо нийлсэн акт үйлдээгүй.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.4ийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Харилцагч байгууллагууд авлага, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй, барагдахгүй байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулан, баталгаажсан дүнг санхүүгийн тайланд тусгаж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,512,754.56	75,280,020.64
33	АВЛАГА	150,000.00	300,362.00
33500	Бусад авлага	150,000.00	300,362.00
33510	Байгууллагаас авах авлага	150,000.00	300,362.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,362,754.56	74,979,658.64
35100	Түүхий эд материал	161,400.00	227,250.00
35130	Эм боох материал	161,400.00	227,250.00
35400	Хангамжийн материал	72,141,354.56	72,307,408.64
35410	Бичиг хэргийн материал	1,957,020.00	7,451,344.00
35420	Аж ахуйн материал	47,374,119.56	50,296,633.64
35440	Түлш, шатах тослох материал	15,096,200.00	6,609,800.00
35460	Хүнсний материал	6,268,265.00	6,080,981.00
35470	Бусад хангамжийн материал	1,445,750.00	1,868,650.00
35600	Мал амьтад	2,060,000.00	2,445,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	529,590,597.98	538,886,028.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	529,590,597.98	538,886,028.72
39200	Биет хөрөнгө	497,564,597.98	506,860,028.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	330,205,600.00	330,205,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-24,862,447.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,528,760.00	17,528,760.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,427,212.00	-9,056,526.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	142,077,353.11	166,593,953.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,225,392.79	-73,612,514.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,138,970.40	80,241,115.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,183,811.44	-34,172,192.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,156,677.30	62,096,677.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-25,184,792.46	-30,179,863.86
39217	Ном	14,478,445.86	22,077,466.86
39300	Биет бус хөрөнгө	32,026,000.00	32,026,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,026,000.00	32,026,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	604,103,352.54	614,166,049.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	170,000.00	170,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	170,000.00	170,000.00
41300	Өглөг	170,000.00	170,000.00
41360	Бусад өглөг	170,000.00	170,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	170,000.00	170,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	603,933,352.54	613,996,049.36
51	Засгийн газрын хувь оролцоо	603,933,352.54	613,996,049.36
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	372,549,179.90	0.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-79,098,989.49	-69,036,292.67
51210	Өмнөх үеийн үр дүн	-50,815,532.56	-79,098,989.49
51220	Тайлант үеийн үр дүн	-28,283,456.93	10,062,696.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	310,483,162.13	310,483,162.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	604,103,352.54	614,166,049.36

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	438,981,581.66	558,324,063.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,542,581.66	492,788,863.80
120	Нийтлэг татварын бус орлого	7,542,581.66	37,788,463.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,542,581.66	37,788,463.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	820,000.00	385,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,722,581.66	37,403,463.80
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	455,000,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0.00	455,000,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	431,439,000.00	65,535,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	429,831,000.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	429,831,000.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,608,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,458,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	150,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	65,535,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	65,535,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	460,987,811.43	548,261,366.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	460,987,811.43	548,261,366.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,920,483.43	531,145,385.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,694,268.00	330,382,315.00
210101	Үндсэн цалин	166,590,555.00	217,011,300.00
210102	Нэмэгдэл	51,831,113.00	79,780,900.00
210104	Урамшуулал	24,869,600.00	33,590,115.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,403,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,284,106.00	41,886,238.00
210201	Тэтгэврийн даатгал	21,429,595.00	28,166,438.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,277,002.00	2,743,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,254,826.00	3,429,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	503,625.00	686,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,819,058.00	6,860,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,084,129.00	66,264,143.00
210301	Гэрэл, цахилгаан	5,092,147.00	5,034,035.00
210302	Түлш, халаалт	61,256,982.00	60,496,308.00
210303	Цэвэр, бохир ус	735,000.00	733,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,941,045.11	14,614,570.00
210401	Бичиг хэрэг	1,903,730.00	1,596,410.00
210402	Тээвэр, шатахуун	1,150,670.00	2,343,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,350.00	556,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,616,295.11	9,578,100.00
2105	Нормативт зардал	24,299,419.00	24,067,035.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,850.00	294,150.00
210502	Хоол, хүнс	24,018,569.00	23,772,885.00

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	40,000.00
210604	Урсгал засвар	0.00	40,000.00
2107	Томилолт, зочны зардал	483,000.00	1,750,000.00
210702	Дотоод албан томилолт	483,000.00	1,750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	679,750.00	486,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	679,750.00	486,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,454,766.32	51,654,234.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,458,000.00	791,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,826,766.32	50,862,334.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,067,328.00	17,115,981.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,342,800.00	16,257,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,105,800.00	15,457,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,000.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	150,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	187,357.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	187,357.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,574,528.00	670,824.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,574,528.00	670,824.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-22,006,229.77	10,062,696.82
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,277,227.16	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,013,726.68	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,050,000.00	0.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	4,213,500.48	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-28,283,456.93	10,062,696.82

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	431,439,000.00	520,535,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	455,000,400.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	455,000,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0.00	455,000,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	431,439,000.00	65,535,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	429,831,000.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	429,831,000.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,608,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,608,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	65,535,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	65,535,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	413,560,000.00	494,861,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,560,000.00	494,861,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,492,672.00	477,745,619.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,382,269.00	330,382,315.00
210101	Үндсэн цалин	160,278,556.00	217,011,300.00
210102	Нэмэгдэл	51,831,113.00	79,780,900.00
210104	Урамшуулал	24,869,600.00	33,590,115.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,403,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,579,900.00	42,036,600.00
210201	Тэтгэврийн даатгал	21,181,200.00	28,316,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,599,600.00	2,743,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,079,700.00	3,429,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,900.00	686,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,199,500.00	6,860,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,814,909.00	57,624,143.00
210301	Гэрэл, цахилгаан	5,092,147.00	5,034,035.00
210302	Түлш, халаалт	63,987,762.00	51,856,308.00
210303	Цэвэр, бохир ус	735,000.00	733,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,103,470.00	6,441,860.00
210401	Бичиг хэрэг	299,950.00	299,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,597,730.00	2,497,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,850.00	573,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	879,940.00	2,530,950.00
2105	Нормативд зардал	28,949,374.00	25,295,601.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	359,950.00	360,000.00
210502	Хоол, хүнс	26,026,924.00	23,585,601.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,562,500.00	1,350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,793,800.00	7,723,700.00

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	4,793,800.00	7,723,700.00
2107	Томилолт, зочны зардал	483,000.00	1,750,000.00
210702	Дотоод албан томилолт	483,000.00	1,750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	739,750.00	760,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	739,750.00	760,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,646,200.00	5,731,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	528,200.00	204,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,118,000.00	5,527,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,067,328.00	17,115,981.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,342,800.00	16,257,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,105,800.00	15,457,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,000.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	150,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	187,357.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	187,357.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,574,528.00	670,824.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,574,528.00	670,824.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,879,000.00	25,674,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	17,879,000.00	25,674,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,879,000.00	25,674,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,879,000.00	25,674,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,879,000.00	25,674,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-17,879,000.00	-25,674,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	340,523,179.90	153,142,116.50	-50,815,532.56	442,849,763.84
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	340,523,179.90	153,142,116.50	-50,815,532.56	442,849,763.84
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	157,341,045.63	0.00	157,341,045.63
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	32,026,000.00	0.00	0.00	32,026,000.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-28,283,456.93	-28,283,456.93
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	-79,098,989.49	603,933,352.54
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	-79,098,989.49	603,933,352.54
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	-79,098,989.49	603,933,352.54
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,062,696.82	10,062,696.82
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	-69,036,292.67	613,996,049.36

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0,00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	520 535 600,00	519 677 419,00	858 181,00	99,8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	520 535 600,00	519 677 419,00	858 181,00	99,8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	503 630 600,00	503 419 619,00	210 981,00	100,0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330 384 800,00	330 382 315,00	2 485,00	100,0
210101	Үндсэн цалин	217 011 300,00	217 011 300,00	-	100,0
210102	Нэмэгдэл	79 780 900,00	79 780 900,00	-	100,0
210104	Урамшуулал	33 592 600,00	33 590 115,00	2 485,00	100,0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42 036 600,00	42 036 600,00	-	100,0
210201	Тэтгэврийн даатгал	28 316 800,00	28 316 800,00	-	100,0
210202	Тэтгэмжийн даатгал	2 743 900,00	2 743 900,00	-	100,0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 429 900,00	3 429 900,00	-	100,0
210204	Ажилгүйдлийн даатгал	686 000,00	686 000,00	-	100,0
210205	Эрүүл мэндийн даатгал	6 860 000,00	6 860 000,00	-	100,0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57 808 500,00	57 624 143,00	184 357,00	99,7
210301	Гэрэл, цахилгаан	5 217 100,00	5 034 035,00	183 065,00	96,5
210302	Түлш, халаалт	51 856 400,00	51 856 308,00	92,00	100,0
210303	Цэвэр, бохир ус	735 000,00	733 800,00	1 200,00	99,8
2104	Хангамж, бараа материалын зардал	6 864 000,00	6 847 860,00	16 140,00	99,8
210401	Бичиг хэрэг	300 000,00	299 700,00	300,00	99,9
210402	Тээвэр, шатахуун	2 500 000,00	2 497 310,00	2 690,00	99,9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576 000,00	573 900,00	2 100,00	99,6
210404	Ном, хэвлэл	406 000,00	406 000,00	-	100,0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550 000,00	540 000,00	10 000,00	98,2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 532 000,00	2 530 950,00	1 050,00	100,0
2105	Нормативт зардал	25 296 000,00	25 295 601,00	399,00	100,0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360 000,00	360 000,00	-	100,0
210502	Хоол, хүнс	23 586 000,00	23 585 601,00	399,00	100,0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 350 000,00	1 350 000,00	-	100,0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24 726 700,00	24 723 700,00	3 000,00	100,0
210601	Багаж, техник, хэрэгсэл	17 000 000,00	17 000 000,00	-	100,0
210604	Урсгал засвар	7 726 700,00	7 723 700,00	3 000,00	100,0
2107	Томилот, зочны зардал	1 750 000,00	1 750 000,00	-	100,0
210702	Дотоод албан томилот	1 750 000,00	1 750 000,00	-	100,0

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760 000,00	760 000,00	-	100,0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	760 000,00	760 000,00	-	100,0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14004000,00	13999400,00	4 600,00	100,0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	204 000,00	204 000,00	-	100,0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13 800 000,00	13 795 400,00	4 600,00	100,0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16905000,00	16257800,00	647 200,00	96,2
2132	Бусад урсгал шилжүүлэг	16 905 000,00	16 257 800,00	647 200,00	96,2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16 105 000,00	15 457 800,00	647 200,00	96,0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800 000,00	800 000,00	-	100,0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	520 535 600,00	519 677 419,00	858 181,00	99,8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	455 000 400,00	454 329 576,00	670 824,00	99,9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	455 000 400,00	454 329 576,00	670 824,00	99,9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65 535 200,00	65 347 843,00	187 357,00	99,7
132001	Орон нутгийн төсвөөс	65 535 200,00	65 347 843,00	187 357,00	99,7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33.00	33.00		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00		
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00		
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	283.00	283.00		
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	283.00	283.00		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.25	Аудитын нэр: Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2020/24/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорноговь аймгийн Дэлгэрэх сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 104 төрлийн хөрөнгө байна	0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Г. Одончимэг
2	Хувь хүн, аж ахуйн нэгж нийт 33 байгууллага тооцоо нийлсэн акт үйлдээгүй.	60,903.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Г. Одончимэг
	Hyundai Starex загварын машин шатахууны тооцоо бодоогүй.	300.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Г. Одончимэг